

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

### Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
  2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.
1. Хуучин чулуун зэвсгийн доод үе аль нь вэ? /1 оноо/  
A. 100.000-40.000 жил      B. 40.000-15.000 жил      C. 800.000-100.000 жил  
D. 15.000-8000 жил      E. 8000-3000 жил
  2. Монгол нутагт одоогоос 730 мянган жилийн өмнө хүн амьдарч байсныг баталсан археологийн олдвор хаанаас олдсон бэ? /1 оноо/  
A. Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул  
B. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуй  
C. Өмнөговь аймгийн Булган сумын Баянзаг  
D. Увс аймгийн Сагил сумын Можоогийн хадны зураг  
E. Дорнод аймгийн Тамсагбулагийн дурсгал
  3. “Соёлт давхарга” гэсэн ойлголт юуг илэрхийлэх вэ? /1 оноо/  
A. Эртний хүмүүсийн багаж, эдлэл, гал голомтын үлдэгдэл газрын хөрсний тодорхой давхаргад хадгалагдан үлдсэн байдал  
B. Эртний хүмүүсийн агуй, урц, хонгил  
C. Төгс оюун ухаант хүний бүтээсэн эд өлгийн зүйлс  
D. Чулуун хутга, чинжаал, жад, зэр зэвсгүүд  
E. Эдгээрээс өөр
  4. Дорнод аймгийн Булган сумын нутгаас эртний хүмүүс нас барагсдыг чулуун онго, сахиус дагалдуулан оршуулдаг байсан олдвор олдсон. Уг дурсгал хаанаас олдсон бэ? /1 оноо/  
A. Чандманы соёл      B. Зураагийн улаан хадны зураг  
C. Тэвш уулын хадны зураг      D. Норовлин уулын булш      E. Орхоны соёл
  5. Их элсэн говиос Байгаль нуур, Солонгосын хойгоос Хар сайр хүртэлх уудам нутагт оршин тогтнож байсан эртний улс аль нь вэ? /1 оноо/  
A. Нирун      B. Киргиз      C. Хүннү      D. Уйгур      E. Хятан
  6. Монгол нутагт оршин байсан эртний Түрэг улсын соёлд хамаарах өгөгдөл байвал олно уу. /1 оноо/  
A. 12 жилийн тоолол, тамга бичиг, ясан хэл хуур  
B. Руни бичиг, Культегиний хөшөө, хүн чулуу  
C. Их, бага бичиг, суврага, гэрэгэ  
D. Ордубалык, манихайн шашин, уйгаржин бичиг  
E. Энд тийм өгөгдөл дурдаагүй байна.
  7. Түүхэн сурвалжид “...ухаалаг, алсын хараатай, төрийн төвшин нуруутай, зохион байгуулах чадвар сайтай, шан харамжинд автагддаггүй, ямагт улс үндэснийхээ эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьдаг, цэрэг улс төрийн зүтгэлтэн байв” хэмээн дурджээ. Уг түүхэн зүтгэлтэн хэн бэ? /1 оноо/  
A. Модунь шаньюй      B. Шэлүнь      C. Моюунчур  
D. Буман      E. Таньшихуай
  8. Эртний Хүннү улс оршин тогтнож байсан цаг хугацааг олно уу. /1 оноо/  
A. НТ I –НТ III зуун      B. НТ 330-555 он      C. НТӨ 209-НТ 93  
D. НТ 745-840 он      E. НТ 901-1125

9. Энэхүү түүхэн дурсгал эртний аль улсад хамаарах вэ?

/2 оноо/

- A. Хүннү
- B. Нирун
- C. Түрэг
- D. Уйгур
- E. Хятан

10. Хамаг Монголын ханлиг хаагуур нутаглаж байсан бэ?

/1 оноо/

- A. Хөлөн Буйр
- B. Халх гол
- C. Сэлэнгийн сав
- D. Хэрлэн, Онон, Туулын сав
- E. Хөвсгөл нуурын орчим

11. Монголын нууц товчоонд Чингис хааны дээд өвгийг хэн гэж бичсэн байдаг вэ?

/1 оноо/

- A. Бугу хатаги
- B. Бэлгүнүтэй
- C. Бүгүнүтэй
- D. Бугути салжи
- E. Бодончар

12. Эзэндээ боол байж байгаад үнэнч зүтгэж, гавъяа байгуулаад чөлөөлөгдөн онгологдож, дархлагдсан хүмүүсийг ямар боол гэж нэрийддэг байсан бэ?

/1 оноо/

- A. Өтөгү боол
- B. Онгу боол
- C. Харьяат боол
- D. Унаган боол
- E. Гэрийн зарц

13. Хамаг Монголын ханлиг байгуулагдсан 1130-аад оныг зууны тоололд шилжүүлсэн зөв илэрхийлэл аль вэ?

/2 оноо/

- A. XII зууны I хагас
- B. XII зууны II хагас
- C. XIII зуун
- D. X зуун
- E. XI зуун

14. Мухулай аль овог, аймгаас гаралтай хүн бэ?

/1 оноо/

- A. Жүрхин
- B. Жадаран
- C. Жалайр
- D. Боржигин
- E. Хатигин

15. Тэмүжинг Хамаг Монголын хаанд 1189 онд өргөмжилсөн газар аль нь вэ?

/1 оноо/

- A. Хэрлэний Хөдөө арал
- B. Хар зүрхний Хөх нуур
- C. Дэлүүн болдог
- D. Хархорум
- E. Онон мөрний эхэн

16. Их Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтад хамаарах бодомжуудаас бурууг олно уу.

/2 оноо/

- A. Шадар хишигтэн нь монгол төрийн аюулгүй байдлыг хамгаалах, төрд үйлчлэх, онц чухал үед цэргийн гол хүч, байнгын бэлтгэлтэй, зэвсэгт хүчний гол цөм болдог байсан.
- B. Чингис хааны нохос буюу жанжидад Борохул, Боорчи, Мухулай, Чулуун нар ордог.
- C. Илдэч бол цэргийн бодлого боловсруулдаг газар.
- D. Мянганы систем нь албан татвар татах, дайн байлдааны үед цэрэг гаргах үүрэг бүхий засаг захиргааны нэгж.
- E. B ба D буруу бодомж

17. Чингис хааны дөрвөн их хөлөг буюу их сайдад хэн, хэнийг нэрлэдэг вэ?

/2 оноо/

- A. Хубилай, Зэлмэ, Зэв, Сүбээдэй
- B. Борохул, Боорчи, Мухулай, Чулуун
- C. Сорхон шар, Шихихутаг, Хар Хирүгэ, Чирхай
- D. Хасар, Хачиун, Тэмүгэ, Шихихутаг, Бэлгүтэй
- E. Мэнлиг, Нэгүүн, Жаха Хамбу, Хүчү

18. XIII-XIV зууны монголчуудын соёлын талаарх дараах бодомжуудад алдаа гаргасан бол аль нь вэ? /2 оноо/
- A. Хархорумаас олдсон төмрийн баасыг орчин үеийн лабортарид хайлуулахад 1350 хэм хүрч байсан.
  - B. Хархорум хотын мөнгөн модыг Мөнх хааны үед Францын уран дархан Вильгельм Бушье урласан.
  - C. XIII-XIV зууны үед Хархорумаас гадна Аураг Орд, Чингай балгас, Хар Түнэ-ийн орд, Хондуй, зэрэг хот суурин, бэхлэлтүүд байсан.
  - D. Хубилай хааны зохиолгосон “Дөрвөн төрийн арван буянт номын цагаан түүх” нь түүх, хууль цаазын шинжтэй дурсгалт бичиг.
  - E. “Чингисийн чулууны бичиг” нь хааны гэрээслэл бичигдсэн дурсгал.
19. Чингис хаан уугуул Монгол нутгаа аль хүүдээ эзэмшүүлсэн бэ? /1 оноо/
- A. Зүчи
  - B. Цагаадай
  - C. Өгөөдэй
  - D. Тулуй
  - E. Борохул
20. “Судрын чуулган” хэмээх түүхэн зохиолыг хэн туурвисан бэ? /1 оноо/
- A. Рашид – ад Дин
  - B. Ата-Малик Жувейн
  - C. Марко Поло
  - D. Плано Карпини
  - E. Гильом Рубрук
21. Монгол хаадын үйл ажиллагаанаас дурдахдаа алдаа гаргасан бол олно уу. /2 оноо/
- 1. Хубилай хаан газар нутгаа өргөтгөх бодлого явуулсан.
  - 2. Хубилай хааны үед Бирм, Камбож, Аннамыг түшмэг улсаа болгожээ.
  - 3. Тогоонтөмөр хааны үед Юан гүрний ноёрхол эцэс болжээ.
  - 4. Гүюг 1247 онд хүн амын тооллого явуулав.
  - 5. Тогоонтөмөр хаан зарлиг буулган Ганжуурыг орчуулсан.
  - 6. Хүлэгү хаан Бээжинд төвлөн сууж Хятадыг захирчээ.
- A. 5, 6
  - B. 1, 4
  - C. 2, 3
  - D. 1, 2
  - E. 1, 3
22. Цагаадайн хаант улсын нийслэл хаана байсан бэ? /1 оноо/
- A. Сарай хот
  - B. Самарканд хот
  - C. Бээжин хот
  - D. Хархорум хот
  - E. Султани хот
23. Мөнх хаан хэзээ, хаана хаан ширээнд өргөмжлөгдсөн бэ? /1 оноо/
- A. 1228 - Хэрлэний Хөдөө арал
  - B. 1246-Шар орд
  - C. 1251- Хэрлэний хөдөө арал
  - D. 1257- Аураг орд
  - E. 1260 – Кайпин
24. Тулуйн хүү Хүлэгү аль улсыг үндэслэсэн бэ? /1 оноо/
- A. Алтан орд
  - B. Ногайн орд
  - C. Астраханы хант улс
  - D. Казаны хант улс
  - E. Ил хаадын улс
25. Цагаадайн хаант улсын түүхэнд холбогдох өгөгдлийг нэрлэнэ үү. /1 оноо/
- A. Дундад Азид оршиж байсан.
  - B. Торгоны гол зам дайран өнгөрдөг.
  - C. Самарканд хот.
  - D. Тамерлан /Төмөр/ хаан
  - E. Дээрх бүгд
26. 1368-1634 он хүртэлх богино хугацаанд 22 хаан төр барьсныг түүхэнд “Бага хаадын үе” гэж нэрлэдэг. Эл үеийг зууны тоололд шилжүүлнэ үү. /1 оноо/
- A. XIV зууны II хагас
  - B. XIV зууны I хагас
  - C. XIII зуун
  - D. XIV зууны II хагасаас XVII зууны I хагас
  - E. XIV зууны II хагасаас XVII зууны II хагас

27. Зургаан түмэн Монголын баруун түмэн нь аль вэ? /2 оноо/  
 A. Халх, Цахар B. Чорос, Хойд C. Ордос, Түмэд, Еншөөбүү  
 D. Барга, Хошууд, Авга E. Халх, Торгууд, Захчин
28. Сагансэцэний “Эрдэнийн товч” зохиолд “Ухаант 1. .... хатан унжсан үсээ дээш эвхэж, улсын эзэн 2. .... хааныг үхэглэж удирдан мордож явсан...” хэмээжээ. Нөхнө үү. /2 оноо/  
 A. 1. Дөргөнө, 2. Гүүг B. 1.Мандухай, 2. Даян C. 1.Самар, 2. Эсэн  
 D. 1. Чихэр, 2. Батмөнх E. 1. Цэвэр, 2.Чингим
29. Түүхэнд Аюушридар хаан ямар нэрээр алдаршсан бэ? /1 оноо/  
 A. Элбэг B. Гүдэн C. Засагт  
 D. Билэгт E. Сэцэн
30. Өндөр гэгээн Занабазарт холбогдохгүй өгөгдлийг олно уу. /2 оноо/  
 1. Анхдугаар Богд 5. Майдар  
 2. Тод үсэг 6. Али гали үсэг  
 3. Соёмбо үсэг 7. Чингисийн алтан ураг  
 4. Хорин нэгэн Дар эх  
 A. 2,6 B. 1,3 C. 1,4 D. 5, 7 E. 7,8
31. 1686 онд Манжийн хааны оролцоотойгоор Халхын баруун, зүүн гарыг эвлэрүүлэх чуулган болж, хоёр талыг тангараг тавиулах ёс гүйцэтгэсэн байдаг. Энэ нь ямар чуулганаар болсон үйл явдал вэ? /2 оноо/  
 A. Мүгдэний чуулган B. Ширээ цагаан нуурын чуулган  
 C. Улаанбураагийн чуулган D. Хүрэн бэлчирийн чуулган  
 E. Долнуурын чуулган
32. “Монголчууд энэ үүлтэй адил, үүл хуралдвал бороо ордог, Монголчууд цуглавал цэрэг болдог. Үүл сарнивал бороо зогсоно. Бид Монголчуудын хүч сарнихыг хүлээж чадвал тэднийг буулган авч чадна” гэж хэн хэлсэн бэ? /1 оноо/  
 A. Энх-Амгалан хаан B. Нурхач хаан C. Абахай хаан  
 D. Тэнгэрийг тэтгэгч хаан E. Бадаргуулт төр хаан
33. 1755-1758 оны зэвсэгт бослогын үеэр Манж нар хүчийг нь сарниулах зорилгоор Хотгойдын Шадар ван Чингүнжавт ямар даалгавар өгсөн байдаг вэ? /2 оноо/  
 A. Хан- Хатан голын Тэлэнгид нарыг дагуулах  
 B. “Хэрэг зөвлөх”-өөр Бээжинд ирэх  
 C. Гэрийн хорионд оруулсан.  
 D. Өвөр Монголыг эзлэх  
 E. Тохирох хариулт алга.
34. Аймаг хошууныхаа ноёд язгууртнуудын мэдэлд захирагдах харъяат ард аль давхаргад хамаарах вэ? /1 оноо/  
 A. Ноёд язгууртнууд B. Суман эр C. Шавь ард  
 D. Лам ард E. Хамжлага ард
35. Нутгийн дотор байгуулсан харуулын албыг хэрхэн нэрийддэг байсан бэ? /2 оноо/  
 A. Дотоод харуул B. Гэр харуул C. Хяраан харуул  
 D. Суман өртөө E. Суурь өртөө
36. Дараах түүхэн үйл явдлуудыг зүй тогтлоор нь зөв дараалалд оруулна уу. /2 оноо/  
 1.Түр Засгийн газар байгуулагдсан.  
 2. Сандог Хүрээнээс хөөсөн.  
 3. Хүрээнээс Манж амбанг гаргах шаардах бичиг өгсөн.  
 4. Олноо өргөгдсөн Монгол улсыг байгуулав.  
 5. Ханддорж, Цэрэнчимэд, Хайсан нар тусламж хүсэхээр Петербургт очсон.  
 A. 5,1,3,2,4 B. 1,2,3,4,5 C. 5,4,3,2,1 D. 1,3,5,2,4 E. 2,3,4,5,1

37. Дараах ойлголтуудыг түүхэн утгаар нь тохируулна уу.

/2 оноо/

- A. Монгол улсын анхны Ерөнхий сайд
- B. 1911 оны хувьсгалын оюун санааны удирдагч
- C. Улсын Хатанбаатар
- D. Улсын Манлайбаатар
- E. Хошой Чин ван

- 1. Магсаржав
- 2. Дамдинсүрэн
- 3. Жибзундамба
- 4. Ханддорж
- 5. Намнансүрэн

- A. a1,b2,c3,d4,e5
- D. a5,b3,c1,d2,e4

- B. a5,b4,c3, d2,e1
- E. a2,b4,c1,d3,e5

- C. a1,b3,c5,d4,e2

38. Улсын доод хуралд аль албан тушаалтан гишүүнээр томилогддог байсан бэ?

/1 оноо/

- A. Яамдын дэс түшмэл
- B. Эх зохиогч түшмэл
- C. Суурин жасааны түшмэл
- D. Яамдын тэргүүн сайд
- E. А,В,С хамаарна.

39. 1920 оны 8 сард анхны долоо Эрхүү хотод очсон. С.Данзан, Д.Чагдаржав, Д.Лосол нар ямар үүрэгтэйгээр Омск, Москва руу явсан бэ?

/1 оноо/

- A. Зөвлөлт Засгийн газрын удирлагатай уулзаж, тусламж хүсэх
- B. Коминтерн, Зөвлөлт засгийн бодлоготой танилцах, цэргийн хэрэгт суралцах
- C. Нутаг орондоо нам, хувьсгалын хэргийг удирдах
- D. Оросоор дамжин Өрнөдийн орнууд руу нэвтрэх
- E. D ба C хамаарна.

40. Ардын намын цэрэгт Сумъяа бэйсийн хошуунаас элссэн хүмүүсийг ямар цэрэг хэмээн нэрлэдэг вэ?

/1 оноо/

- A. Цахар цэрэг
- D. Хошуу цэрэг

- B. Цоохор цэрэг
- E. Торгон цэрэг

- C. Шадар цэрэг

41. Хиагтын Дээд шивээнд болсон хурлаар Монгол ардын засгийн хэргийг түр ерөнхийлөн захирах газар буюу АТЗГ-ыг 7 хүнтэй байгуулсан. Хэзээ болсон үйл явдал вэ?

/1 оноо/

- A. 1920. 6.25
- E. 1921. 7.11

- B. 1921 . 3.1-3

- C. 1921. 3.13

- D. 1921. 3.18

42. 1923 онд Монгол улсын засаг захиргааны хуваарьт өөрчлөлт гарсан. Хуучны Сэцэн хан аймгийг хэрхэн нэрлэсэн бэ?

/1 оноо/

- A. Богд хан уулын аймаг
- C. Цэцэрлэг мандал уулын аймаг
- E. Хантайшир уулын аймаг

- B. Хан Хэнтий уулын аймаг
- D. Чандмань уулын аймаг

43. "... Богд хаанаа эрдэнийн сууринаа хэвээр залж, өргөмжлөн элдэв хэргийг явуулж бүхий нь бурхны шашнаа хүндэлж, ард түмнийг амгалан туйл дор хүргүүлэн тэгш журамт, баян хүчирхэг улс болохыг гол болгосон хэрэг болой..." гэсэн Д.Сүхбаатарын үзэл байдаг. Уг баримтын агуулгад нийцүүлэн хийсэн дүгнэлтэд аль нь хамааралгүй вэ?

/2 оноо/

- A. Богдыг хаан ширээнд хэвээр байлгана.
- B. Төр нь шашнаа хүндэтгэнэ.
- C. Тэгш эрхтэй чинээлэг баян орон болно.
- D. Ард олны ашиг сонирхлыг эрхэмлэнэ.
- E. Хэмжээгүй эрхт хаант засаглалыг тууштай бэхжүүлнэ.

44. "...Бид Монголын өвөрмөц байдлыг харгалзах ёстой. Монголын нутаг дэвсгэр Англи, Герман, Францынхыг нийлүүлснээс өргөн уудам, хүн ам нь дөнгөж 800,000. .... Монголыг империалистуудын нөлөөнд оруулахгүй байхыг хичээх нь 800,000 малчин хүн амтай улс оронд социализм байгуулахаас илүү чухал зорилт мөн..." гэж хэлсэн нь хэний үг вэ?

/1 оноо/

- A. М.И. Амагаев
- E. Э.Ринчино

- B. Б.Шмераль

- C. И.В. Сталин

- D. М.И.Кучеренко

45. 1937 оны 10 сарын 2-нд Х.Чойбалсангаар толгойлуулсан УБХ-ын гишүүн Д.Лувсаншарав, Шүүх яамны сайд Г.Цэрэндорж нарын 3 хүний бүрэлдэхүүнтэй, үй олноор баривчлагдсан хүмүүсийн хэргийг шуурхай шийдвэрлэх зорилготойгоор байгуулсан байдаг. Энэ нь түүхэнд юу гэж нэрлэгдсэн бэ? /2 оноо/
- A. Онц бүрэн эрхт комисс  
B. Феодал агсдын хөрөнгө хураах комисс  
C. Улсын онцгой комисс  
D. Шинэ эргэлтийн бодлого  
E. Тохирох хариулт алга.
46. 1932 оны зэвсэгт бослогын үеэр босогчид өөрсдийгөө хэрхэн нэрийдсэн байдаг вэ? /1 оноо/
- A. Шамбалын цэрэг  
B. Шарын цэрэг  
C. Улааны цэрэг  
D. Шашныг мандуулагч цэрэг  
E. D ба C хамаарна.
47. Их хэлмэгдүүлэлтийн хоморголон баривчлах харгис үйл ажиллагаа хэзээ эхэлсэн бэ? /1 оноо/
- A. 1934. 7.27  
B. 1936. 3.12  
C. 1937. 9.10  
D. 1939.5 сар  
E. 1939.9.16
48. Халх голын дайны тухай өгүүлэхдээ алдаа гаргасан бол аль нь вэ? /2 оноо/
- A. Халх голын дайнд Япон, Манж Го-гийн хүчний эсрэг БНМАУ, ЗСБНХУ хамтарсан хүчээр тулалдсан.  
B. 1936 онд зэвсэг, техникийн хангамжийг 40 хувь нэмэгдүүлсэн.  
C. Дайнд хоёр талаас 130 гаруй мянган хүн оролцож, 1000 орчим танк хэрэглэсэн.  
D. Халх голын дайнд Л.Дандар, Ц.Олзвой, Л.Гэлэгбаатар, П.Чогдон нарын 13 хүнд БНМАУ-ын баатар цол олгосон.  
E. Халх голын дайн 1945 оны 5 сарын 9-нд дууссан.
49. 1961 оны 10 сарын 27-ны өдөр Монгол улсын түүхэнд ямар томоохон үйл явдал болсон бэ? /2 оноо/
- A. Нэгдэлжих хөдөлгөөн өрнөсөн.  
B. Их гүрнүүд БНМАУ-ын “статус-кво”-г хүлээн зөвшөөрсөн.  
C. Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэсэн.  
D. БНМАУ Нэгдсэн Үндэстний Байгууллагад гишүүнээр элссэн.  
E. Дундад Иргэн улс Монголын тусгаар тогтнолыг зөвшөөрсөн.
50. 1963 онд НТХ-ны V бүгд хурлаар НТХ-ны хоёрдугаар нарийн бичгийн дарга Л.Цэндийг нам, төрийн удирдлагаас зайлуулах болсон гол шалтгаан юу байсан бэ? /2 оноо/
- A. Үндсэрхэг үзлийг дэвэргэж, хэт туйлширсан.  
B. Хувьсгалаар олж авсан ард түмний ололтыг үгүйсгэсэн.  
C. Монгол- Зөвлөлтийн ах дүүгийн найрамдалд үл итгэсэн  
D. Эрх тушаал хөөцөлдсөн, боловсон хүчнийг хяхан хавчсан.  
E. А ба В хамаарна.
51. “БНМАУ-ын зорилго бол социализмыг төгөлдөр байгуулж, цаашдаа коммунист нийгэм байгуулах явдал мөн” гэж тодорхойлсон нь аль Үндсэн хууль вэ? /2 оноо/
- A. 1924 оны Үндсэн хууль  
B. 1940 оны Үндсэн хууль  
C. 1960 оны Үндсэн хууль  
D. 1992 оны Үндсэн хууль  
E. МАХН-ын IV программ
52. Социализмын үеийн нийгмийн эдийн засгийн амьдралын хүрээний онцлог шинжүүдийг дурдахдаа алдаа гаргасан бол олно уу. /2 оноо/
- A. Төрийн мэдэлд улс, нийгмийн өмч ноёрхсон.  
B. Эдийн засгийг төвлөрсөн төлөвлөгөөгөөр удирддаг.  
C. Хатуу үнийн систем үйлчилдэг.  
D. Гадаад худалдаа либеральчлагдаагүй.  
E. Валютыг хөрвөх ханшид шилжүүлсэн.
53. “Цогт тайж” түүхэн кино зохиолыг туурвисан зохиолч хэн бэ? /1 оноо/
- A. Ш.Нацагдорж  
B. Б.Ринчен  
C. Д.Намдаг  
D. Л.Түдэв  
E. Х.Пэрлээ

54. 1990 оны 3 сарын 9-ний өдрийн 19 цагт Монгол улсын түүхэнд ямар чухал үйл явдал болсон бэ? /2 оноо/
- A. Нам төрийн удирдлага ба шинэ хүчний удирдагчдын оролцсон “Дугуй ширээний ярилцлага” болов.
  - B. Монголын ардчилсан холбооны 10 гишүүн, нийт 30 гаруй хүн оролцсон анхны улс төрийн өлсгөлөн болсон.
  - C. Монгол улсын Шинэ үндсэн хууль батлав.
  - D. Монголын ардчилсан холбоо байгуулагдсанаа зарласан.
  - E. Анхны чөлөөт ардчилсан сонгууль явагдсан.

55. Өмч хувьчлалын хууль 1991 оны 5 сарын 31-ний өдөр батлагдаж, үүнээс өмнө төрсөн Монгол улсын иргэдэд эрхийн бичиг олгожээ. Их хувьчлалын хэлбэр аль вэ? /2 оноо/
- A. Ягаан тасалбар
  - B. Цэнхэр тасалбар
  - C. Мал хувьчлал
  - D. Оюуны өмчийн эрх
  - E. Улсын ба хувийн өмч

56. Монгол улсын шинэ Үндсэн хуулийн агуулгад үл нийцэх бодомж аль вэ? /2 оноо/
- A. Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.
  - B. Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.
  - C. Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.
  - D. Улсын их хурал нь хоёр танхимтай.
  - E. Улсын их хурал нь ард түмнээсээ 4 жилийн хугацаатай шууд сонгогдоно.

### ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ, ДАРААЛАЛ СЭРГЭЭХ ДААЛГАВАР

#### Санамж:

1. Даалгаврын хариуг зөв тогтоож харгалзуулах, дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү.
2. Зөв хариулт бүр нэг оноотой.

- 2.1. Монголын түүх, археологийн дараах дурсгалууд олдсон газрыг одоогийн аймаг, нутгаар нь тохируулан нэрлэнэ үү. /5 оноо/

- A. Можоогийн хадны сүг зураг /мезолит/
- B. Долоон модны мэлхий дээрх гэрэлт хөшөө /Түрэг/
- C. Ноён уулын язгууртны булш /Хүннү/
- D. Бичгийн бийр, янтай /Хүннү/
- E. Мөнх хааны гэрэлт хөшөө

- 2.2. Дараах ойлголтуудыг түүхэн утгаар нь зөв харгалзуулна уу. /5 оноо/

- A. Ноён уулын амьтны дүрст ширдэг
  - B. Цамбагарав уулын морин цэргийн хадны зураг
  - C. Культегиний гэрэлт хөшөө
  - D. Долоодойн булшны гэрэлт хөшөө
  - E. Хэрлэн барс хотын суврага
- 1. Түрэг
  - 2. Хүннү
  - 3. Уйгур
  - 4. Хятан
  - 5. Нирун

- 2.3. Дараах түүхэн зүтгэлтнүүдийн амьдарч байсан он цагийн дарааллаар нь эрэмбэлнэ үү. /5 оноо/

- A. Доголон Төмөр
- B. Батмөнх даян хаан
- C. Чин ван Ханддорж
- D. Галдан бошигт хаан
- E. Амарсанаа

- 2.4. Дараах түүхэн үйл явдлуудыг цаг хугацаагаар нь зөв харгалзуулна уу. /5 оноо/

- A. Өвөр Монгол Манжид эзлэгдэв.
  - B. Монгол-Ойрадын их цааз батлагдав.
  - C. Халх Монгол Манжид эзлэгдэв.
  - D. Буурын гэрээгээр Монгол, Оросын хилийг тогтоов.
  - E. Зүүнгар /Ойрад/ Манжид эзлэгдэв.
- 1. 1758 он
  - 2. 1691 он
  - 3. 1640 он
  - 4. 1727 он
  - 5. 1636 он